# ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Л.ОЮУНГЭРЭЛИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах** | | | | | | | |
| 1 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлэр | - | Бодлогын баримт бичиг болон үндэсний хөтөлбөр, хууль тогтоомжид тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулан, хяналт тавьж, биелэлтийг нэгтгэн гаргаж, хугацаанд нь тайлагнана. | **Биелэлт:**<br>1.Гаалийн байгууллагын 2023 оны жилийн эцсийн дараах эрх зүйн акт, бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг нэгтгэн боловсруулж, СЯ-нд хугацаанд нь хүргүүлж, тайлагнасан.Үүнд:<br>-Сангийн сайдын шийдвэр, өгсөн үүрэг даалгаврын биелэлт,<br>-“Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний биелэлт,<br>-Улсын төсөв, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилт,<br>-Гаалийн ерөнхий газрын жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт,<br>-Агентлагийн бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт,<br>-“Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах үйл ажиллагааны хэрэгжилт,<br>-Аудит, хяналт шалгалтын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийн биелэлт,<br>-Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээний тайлан,<br>-“Дотоод аудитын хорооны тогтоолоор ирүүлсэн зөвлөмжийн тайлан,<br>-Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт “төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт/-ийн биелэлт.<br>2.Гаалийн байгууллагын 2024 оны эхний хагас жилийн дараах эрх зүйн акт, бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг нэгтгэн боловсруулж, СЯ-нд хугацаанд нь хүргүүлж, тайлагнасан.Үүнд:<br>-“Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн тайлан,<br>-Гаалийн байгууллагын “Шударга байдлын үнэлгээ”-г 2024 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн тайлан,<br>-Гаалийн байгууллагын 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, | 01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -"АТГ-аас ГЕГ-т ирүүлсэн зөвлөмжийн тайлан,<br>- Гаалийн байгууллагын төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах хүснэгт.<br>**Хүрсэн түвшин:**<br>Сангийн сайдын 2018 оны 143 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад заасны дагуу 2023 оны жилийн эцсийн болон 2024 оны эхний хагас жилийн гаалийн байгууллагын бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн боловсруулж, СЯ-нд хугацаанд нь хүргүүлсэн. Хугацаа хоцроосон тайлан байхгүй болно. | | |
| 2 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлэ эр | - | Захиргааны удирдлагын газрын үйл ажиллагаанд хамааралтай бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнана. | **Биелэлт:**<br>Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд "Алсын хараа-2050" МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого, "ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г тус тус боловсруулан ГЕГ-ын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.<br>Захиргааны удирдлагын газрын үйл ажиллагаанд хамааралтай бодлогын баримт бичгийн хэрэгжүүлэх арга хэмжээ тусгагдаагүй тул тайлагнаагүй бөгөөд нэгжийн чиг үүрэгт хамаарал бүхий арга хэмжээг тусгасан тохиолдолд хэрэгжилтийг хангаж ажиллаж, тухай бүр нь тайлагнан ажиллах болно.<br>**Хүрсэн түвшин:**<br>Захиргааны удирдлагын газрын үйл ажиллагаанд хамааралтай бодлогын баримт бичгийн хэрэгжүүлэх арга хэмжээ тусгагдаагүй тул тайлагнаагүй бөгөөд нэгжийн чиг үүрэгт хамаарал бүхий арга хэмжээг тусгасан тохиолдолд хэрэгжилтийг хангаж ажиллаж, тухай бүр нь тайлагнан ажиллах болно. | 01.01-12.10 | 100 |
| **Зорилт 4."Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх"** | | | | | | | |
| 1 | Гаалийн байгууллагын стратеги төлөвлөгөө болон гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөн | Хэрэгжилт, гүйцэтгэлэ эр | - | 1. Гаалийн байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулан, тайлагнаж, олон нийтэд ил тод болгоно.<br>2.Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа | **Биелэлт:**<br>-2024.01.22-ны өдөр "Гаалийн байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г боловсруулж, Сангийн сайдаар батлуулсан."Гаалийн байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө" нь 4 зорилтын хүрээнд 37 арга хэмжээнээс бүрдсэн. ОНХА-нд хүргүүлэн олон нийтэд ил тод болгосон.<br>-ЗУГ, ХБГ, ХНХ, ХЦХ, ЭНСТ зэрэг ГЕГ-ын ЗББНДБ болон Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Ховд аймгийн Булган дахь гаалийн газар, Хөвсгөл аймгийн Ханх дахь гаалийн хорооны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тэдгээрийн дарга нарын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж, батлуулах ажлыг зохион байгуулсан.<br>-Гаалийн ерөнхий газрын нийт 242+26 төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөх, батлуулах ажлыг зохион байгуулж, төлөвлөгөөний 1 хувийг хувийн хэргийн баяжилт хийлгэхээр ХНХ-т, 1 хувийг архивын нэгж үүсгэхээр ААҮАд тус тус хүргүүлсэн. | 01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ий хэрэгжилт, үр дүн | | | гаалийн газар, хороод болон тэдгээрийн дарга нарын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулна. 3.Гаалийн ерөнхий газрын төрийн жинхэнэ албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөх, батлуулах ажлыг зохион байгуулж, архивын нэгж үүсгэсэн байна. | **Хүрсэн түвшин:**<br>-2024.01.22-ны өдөр "Гаалийн байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г боловсруулж, Сангийн сайдаар батлуулсан. ОНХА-нд хүргүүлэн олон нийтэд ил тод болгосон.<br>-Өөрийн хариуцсан Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороодын 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хянаж, дүгнэх ажлыг хэрэгжүүлсэн.<br>-Гаалийн ерөнхий газрын нийт 242+26 төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөх, батлуулах ажлыг зохион байгуулж, төлөвлөгөөний 1 хувийг хувийн хэргийн баяжилт хийлгэхээр ХНХ-т, 1 хувийг архивын нэгж үүсгэхээр ААҮА-д тус тус хүргүүлсэн.<br>-Жилийн эцсийн тайлан, үнэлгээний хуудсыг хүлээн авах ажлыг зохион байгуулж байна. | | |
| 2 | Хөдөлмөрийн дотоод журам, Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандартын хэрэгжилт, үр дүн | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Хөдөлмөрийн дотоод журам, Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандарт болон захиргааны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангуулсан байна. | **Биелэлт:**<br>Хөдөлмөрийн дотоод журам, Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандарт болон захиргааны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах ажлыг хийсэн. Үүнд:<br>-Гаалийн удирдах төв байгууллагын дарга, удирдлагуудын иргэд, аж ахуйн нэгжийн төлөөллийг хүлээн авч, уулзах уулзалтын хуваарийг ажлын 5 өдөөр гаргаж, мэдээллийн самбарт болон цахим хуудсанд байршуулсан. https://customs.gov.mn/%d1%85%d0%be%d0%bb%d0%b1%d0%be%d0%be-%d0%b1%d0%b0%d1%80%d0%b8%d1%85/<br>-"ГУБ-ийн үйлчилгээний стандарт", "ГУБ-ийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг хэрэглэх журам"-ыг нийт албан хаагчиддаа танилцуулах ажлыг зохион байгуулж, гарын үсгээр баталгаажуулан ирүүлэх, мөн журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 2024.03.04-ний өдрийн 01-1/818 албан бичгийг харьяа гаалийн газар, хороодод, 2024.03.04-ний өдрийн 39 дүгээр дотоод зурвасыг ГЕГ-ын ЗББНДБ-д хүргүүлсэн. Албан бичиг, дотоод зурвасын дагуу ирүүлсэн баталгаажуулалтыг нэгтгэн боловсруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Хөдөлмөрийн дотоод журам, Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандарт болон захиргааны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, зааврын биелэлтийг хангах ажлын хэрэгжилт бүрэн хангагдсан. | 01.01-12.10 | 100 |
| 3 | Албан хаагч хуулиар хүлээсэн | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын | **Биелэлт:**<br>-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 31.1-д заасан шаардлагыг хангаж, Үндэсний итгэмжлэлийн төвөөс ажлын байрны | 01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үүргээ биелүүлэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, албан хаагчийн хууль ёсны эрх ашиг зөрчигдсөн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх чиглэлээр зохион байгуулсан ажил | | | бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагын нийт албан хаагчдын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх талаар үр дүнтэй арга хэмжээг /санал авч, нэгтгэн боловсруулах, албан бичиг хүргүүлэх гэх мэт/ зохион байгуулна.<br>2.Албан хаагч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, албан хаагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах чиглэлээр арга хэмжээ зохион байгуулсан, тайлагнасан байна. | хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийхээр итгэмжлэгдсэн техникийн хяналтын байгууллага /нийт 7 байгууллага/-уудыг судалж, холбогдон Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагын албан хаагчдын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх талаар үнийн санал авсан.<br>-Албан хаагч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, албан хаагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах чиглэлээр дараах арга хэмжээг зохион хэрэгжүүлсэн. Үүнд:<br>-ААҮА-ны үйлчлэгч Б.Балжиннямын өргөдөл, эмчийн үзлэгийн хуудас, оношлогоотой танилцаж, “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгааныг судлан бүртгэсэн акт” тогтоох боломжгүй болох талаар 2024.01.25-ны өдрийн 01-2.1/336 албан бичгийг хүргүүлсэн.<br>-Замын-Үүд дэх гаалийн газрын гаалийн улсын байцаагч Б.Энхцэцэг нь авто замын ослоор нас барсан болох, түүний ар гэрээс ирүүлсэн тэтгэмж хүссэн өргөдөл, Замын-Үүд дэх гаалийн газрын 2024.03.04-ний өдрийн 01/55 албан бичгээр ирүүлсэн мэдээлэл, тайлбар зэрэг холбогдох материалуудтай танилцан асуудлыг судалж, хэлэлцэн “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам” -ын 11.2.4 дэх заалтын дагуу /“Тэтгэмж олгох тухай” ГЕГ-ын даргын 2024.03.27-ны өдрийн Б/229 дүгээр тушаал/ шийдвэрлүүлсэн.<br>-“Гаалийн ерөнхий газрын “Б” блокийн 210 тоот өрөөний агаарын бохирдол их, агааржуулалт, байгалийн гэрэлтүүлэг муу, дуу чимээ, доргио ихтэй, тус өрөөний чанх дээд талд буюу 3-р давхарт лабораторийн химийн хүчлийн задлан шинжлэх шинжилгээ хийгддэг, доод талд буюу 1-р давхарт нүүрс бутлах шинжилгээ хийгддэгээс шалтгаалан өдөр тутамдаа хордож, эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж байгаа” талаар ХЦХ-ийн гаалийн улсын байцаагч А.Алтанхундагын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн гомдол /амаар гаргасан/ болон түүний эрүүл мэндийн байдлыг харгалзан үзэж, 2024.04.19-ний өдрийн 2024/01 дугаар **“Нэн даруй хэрэгжүүлбэл зохих албан шаардлага”** -ыг ААҮА-ны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Нарангэрэлд хүргүүлсэн.<br>-ЭНСТ-ийн 2024 оны 2024/45 дотоод зурвасаар ЭНСТ-ийн болон харьяа гаалийн газар, хороодын эрэлч нохойн чиглэлээр ажиллаж байгаа албан хаагч нарт Хөдөлмөрийн тухай хуулийн 108.1-д заасан хэвийн бус нөхцөлд ажилласны нэмэгдлийг олгож өгөхийг хүссэн хүсэлт ирүүлсэн. Дээрх хүсэлтийг судлан үзэж, энэ талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө, чиглэл авахаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт “Чиглэл хүсэх тухай” 2024 оны 01-1/2970 албан бичгийг хүргүүлсний дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга Ч.Алимаагаас 2024 оны 09/89 албан бичгээр хариуг ирүүлсэн. Тус албан бичигт:<br>Ажил олгогч нь хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсэн газруудад ажлын байрны хэвийн бус нөхцөлийг хэвийн болгох үүрэгтэй бөгөөд энэ | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | арга хэмжээг авах хүртэл Хөдөлмөрийн тухай хуулийн 120.3-т заасан ажлын цагийг богиносгох, нэмэлт амралт, хэвийн бус нөхцөлд ажилласны нэмэгдлийг олгох зэрэг шаардлагатай түр арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн авах боломжтой, харин бусад харьяа гаалийн газар, хороодод хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэх нь зүйтэй гэсэн байна. Иймд ХНХ-т болон ЭНСТ-д ЗУГ-ын 2024 оны 113 дугаар дотоод зурвасаар дээрх албан бичгийг хүргүүлсэн.<br>-Гаалийн байгууллагын албан хаагчдын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн хими, физик, физиологийн хүчин зүйлийн үнэлгээ хийлгэх санал авахаар 2024.08.14-ний өдрийн 01-1/3239 албан бичгийг харьяа гаалийн газар, хороодод, 2024.08.14-ний өдрийн №118 дугаар дотоод зурвасыг зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагад хүргүүлж, ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулж, үнэлгээ хийж, дүгнэлт гаргасан. Мөн удирдлагад танилцуулсан.<br>Нэгдсэн дүгнэлтээс харахад гаалийн байгууллагын хэмжээнд ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх дундаж хэмжээний эрсдэлтэй гэж үзсэн ГЕГ-ын ХЦХ, МТГ, ШХТ гэсэн 3 нэгжийн оффисын ажлын байр, эрсдэлийн түвшин өндөр буюу ихээхэн хэмжээний эрсдэлтэй бөгөөд ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх зайлшгүй шаардлагатай ОрГГ, ШХГГ, ГСГГ гэсэн 3 гаалийн газар, бүх харьяа гаалийн газар, хороодын цөмийн болон цацрагийн хяналт хариуцсан ГУБ, химийн хорт болон аюултай бодисын хяналт хариуцсан ГУБ, рентген тоног төхөөрөмж хариуцсан ГУБ, эрэлч нохой хариуцсан ГУАБ, эрэлч нохой хариуцсан ГУБ, мэдээллийн технологи хариуцсан ГУАБ, мэдээллийн технологи хариуцсан ГУБ, архивын эрхлэгч, бичиг хэргийн эрхлэгч, бичиг хэрэг, архивын эрхлэгч, нярав, ариутгагч, галч гэсэн албан тушаалын ажлын байрнууд байна.<br>-"Мэдээллийн цаг"-аар "ХАБЭА-н ойлголт" сэдвээр сургалт авах ажлыг зохион байгуулж, "Эрхэс сувд" ХХК-аар сургалт хийлгэж, ГЕГ, ХГГХ-ны 527 албан хаагчийг хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>1.ГЕГ-ын ЗББНДБ-ууд болон харьяа 19 гаалийн газар, хороодоос ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх саналыг авч, нэгтгэн боловсруулж, дүн шинжилгээ хийж дүгнэлт, саналыг ГЕГ-ын даргад танилцуулан ажилласан. Ирүүлсэн саналд үндэслэн 2025 оны төсөв, хөрөнгөнд тааруулан хэсэгчлэн хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг ирэх онд хийлгэхээр болсон. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийдэг итгэмжлэгдсэн байгууллагын судалгаа хийж, үнийн саналыг авч, нэгтгэн ажилласан.<br>2.ГЕГ-ын дэргэдэх ЭНСТ-ийн албан хаагчдад хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл олгох асуудлаар Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас чиглэл авч, хариуг ХНХ, ЭНСТ-д тус тус хүргүүлэн ажилласан.<br>3.Албан хаагч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, албан хаагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | чиглэлээр 4 албан хаагч /3 албан хаагч, 1 нас барсан албан хаагчийн ар гэрийн/-ийн санал, хүсэлтийг шийдвэрлэсэн. | | |
| 4 | Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар хороодын үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, удирдамж чиглэлээр хангаж ажилласан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлэр | - | Харьяалагдах нэгж, харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагааг чиг үүргийн хүрээнд удирдлага, арга зүйгээр хангана. | **Биелэлт:**<br>Харьяалагдах нэгж, харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагааны уялдаа холбоо, удирдлага, арга зүйгээр хангах ажлын хүрээнд дараах ажлыг хийсэн. Үүнд:<br>-ЗУГ, ХБГ, ХНХ, ХЦХ, ЭНСТ зэрэг ГЕГ-ын ЗББНДБ болон Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Ховд аймгийн Булган дахь гаалийн газар, Хөвсгөл аймгийн Ханх дахь гаалийн хорооны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тэдгээрийн дарга нарын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж, батлуулах ажлыг зохион байгуулсан.<br>-Өөрийн хариуцсан ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага болох ХНХ-т 20 дотоод зурвасыг, ОНХА-д 8 дотоод зурвасыг тус тус хүргүүлж, чиг үүргийн хүрээнд удирдлага, арга зүйгээр хангаж ажилласан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Харьяалагдах нэгж, харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагааг чиг үүргийн хүрээнд удирдлага, арга зүйгээр хангаж ажилласан. | 01.01-12.10 | 100 |
| 5 | Авлигын эсрэг үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулсан ажил | Хэрэгжилт, гүйцэтгэлэр | - | 1. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулна.<br>2. "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний дагуу үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулж ажиллана.<br>3. "Гаалийн байгууллагын "Шударга байдлын үнэлгээ"-г 2024 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө" | **Биелэлт:**<br>-2024.03.20-ны өдөр "Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулж, АТГ-аар хянуулан ГЕГ-ын даргаар батлуулсан.<br>-Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах, тайлагнах талаар харьяа гаалийн газар, хороодод 2024.03.22-ны өдрийн 02/1094 албан бичгийг, ГЕГ-ын ЗББНДБ-д 2024 оны 47 дугаар дотоод зурвасыг хүргүүлсэн.<br>-"Гаалийн байгууллагын "Шударга байдлын үнэлгээ"-г 2024 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө"-ний төсөл боловсруулан ГЕГ-ын ЗББНДБ-аас санал авч, нэгтгэн боловсруулсан /3 зорилтын хүрээнд 12 арга хэмжээнээс бүрдсэн/ төлөвлөгөөг 2024.04.01-ний өдөр ГЕГ-ын даргаар батлуулсан.<br>-Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах, тайлагнах талаар харьяа гаалийн газар, хороодод 2024.04.05-ны өдрийн 01-1/1311 албан бичгийг, 2024 оны дүгээр 59 дүгээр дотоод зурвасыг ГЕГ-ын ЗББНДБ-д хүргүүлсэн.<br>-"Гаалийн байгууллагын "Шударга байдлын үнэлгээ"-г 2024 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө" болон "Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд тусгагдсан ажлуудаас ГЕГ- | 01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | боловсруулж, батлуулна.<br>4. “Гаалийн байгууллагын “Шударга байдлын үнэлгээ”-г 2024 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө”-ний дагуу үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулж ажиллана.<br>5.”Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Гаалийн байгууллагын “Шударга байдлын үнэлгээ”-г 2024 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө”-ний болон зөвлөмжийн биелэлтийн тайланг нэгтгэн боловсруулж, хүргүүлнэ. | ын холбогдох нэгж, АТГ-ын УССГХ-тэй хамтран хийж хэрэгжүүлэх ажлын саналыг авахаар 2024.04.10-ны өдрийн 01-1/1369 албан бичгийг харьяа гаалийн газар, хороодод, 2024 оны 66 дугаар дотоод зурвасыг ГЕГ-ын ЗББНДБ-д хүргүүлж, ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулсан.<br>-“Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 2.1-т заасан “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд журамд заасан чиглэлүүдээс ямар төрлийн үйл ажиллагаанд хөндлөнгийн байгууллагаар мониторинг хийлгэх шаардлагатай байгаа талаар санал авахаар 2024 оны 85 дугаар дотоод зурвасыг ГЕГ-ын ЗББНДБ-д хүргүүлсэн.<br>-“Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн тайланг 2024.06.26-ны өдрийн 01/2629 албан бичгээр АТГ-ын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваад хүргүүлсэн.<br>- Гаалийн байгууллагын “Шударга байдлын үнэлгээ”-г 2024 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн тайланг 2024.06.27-ны өдрийн 01-1/2678 албан бичгээр АТГ-ын УССГХ-ийн дарга, эрхэлсэн комиссар Х.Ихмөрөнд хүргүүлсэн.<br>-“АТГ-аас ГЕГ-т ирүүлсэн зөвлөмжийн тайланг 2024.06.27-ны өдрийн 01-1/2677 албан бичгээр АТГ-ын УССГХ-ийн дарга, эрхэлсэн комиссар Х.Ихмөрөнд хүргүүлсэн.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт хангагдсан. | | |
| 6 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Олон нийтийн арга хэмжээ, уулзалт, хурал, ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулна. | **Биелэлт:**<br>Олон нийтийн арга хэмжээ, уулзалт, хурал, ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулах ажлын хүрээнд:<br>-Гаалийн байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөн 2024.01.18-19-ний өдрүүдэд Гаалийн ерөнхий газрын төв байранд зохион байгуулагдсан бөгөөд тус зөвлөгөөний бэлтгэл ажлыг хангаж ажиллаж, нийт 8 албан бичгээр холбогдох дарга нарт урилга хүргүүлсэн. Тус сургалт, зөвлөгөөний хөтөлбөрийг боловсруулсан.<br>-”Гаалийн байгууллагын ширээний теннисний тэмцээн”-д зориулсан теннисний ширээний түрээс болон шүүгч нарын төсвийг боловсруулж, батлуулсан.<br>-”XVII жарны "Хилэнт эх" хэмээх модон луу жилийн цагаан сарын шинийн 4-ний өдрийн золгох арга хэмжээний хөтөлбөр”-ийг боловсруулсан.<br>-2024.10.01-ний ахмадын өдрийг тохиолдуулан Гаалийн ерөнхий газраас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх | 01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | арга хэмжээг Гаалийн ерөнхий газрын 9-р давхрын хурлын танхимд зохион байгуулсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>Тайлант хугацаанд нийт 4 удаагийн олон нийтийн арга хэмжээ, уулзалт, хурал, ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангаж зохион байгуулан ажилласан. | | |

## Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино, дунд хугацааны болон цахим сургалтад хамрагдах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор | - | Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна. | Тайлант хугацаанд дараах сургалтад хамрагдаж, мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн.Үүнд:<br>-Удирдлагын академийн 2024.02.26-ны өдрийн "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны хуулийн төсөл" хэлэлцүүлэг,<br>-Төрийн албаны зөвлөлийн 2024.03.07-ны өдрийн "Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн төслийг танилцуулах "7:4:10" цахим сургалт,<br>-Төрийн албаны зөвлөлийн 2024.04.11-ний өдрийн "Монгол төрийн зүтгэлтний хэв шинж" сэдвийн хүрээнд "7:4:10" цахим сургалт,<br>-Төрийн албаны зөвлөлийн 2024.09.12-ны өдрийн "Гадаад улсын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломж, үр дүн" сэдвийн хүрээнд "7:4:10" цахим сургалт,<br>-Төрийн албаны зөвлөлийн 2024.10.17-ны өдрийн "Нийгмийн даатгалын эрх зүйн орчны шинэтгэл, хуулийн хэрэглээ" сэдвийн хүрээнд "7:4:10" цахим сургалт. | 01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Албан хэрэг хөтлөлтийн талаарх мэдлэгээ дээшлүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Бие дааж уншиж судалсан байна. | “Архивын тухай” хууль, “Монгол хэлний тухай” хууль, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”, Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллагад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн программ хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх журам”, Стандарт, хэмжилзүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан “Баримт бичиг стандарт MNS5140:2021” зэрэг баримт бичгийг тус тус уншиж судалснаар албан хэрэг хөтлөлтийн талаарх мэдлэгээ зохих түвшинд дээшлүүлсэн. | 01.01-12.10 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ................ /Л.ОЮУНГЭРЭЛ/ 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Л.ОЮУНГЭРЭЛИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Захиргааны удирдлагын газар

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, эрх зүйн актын хэрэгжилт | 60 | 10 | 70 | |
| 2 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 4.“Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх” арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1 | Гаалийн байгууллагын стратеги төлөвлөгөө болон гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн | 60 | 10 | 70 | |
| 2 | Хөдөлмөрийн дотоод журам, Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандартын хэрэгжилт, үр дүн | 60 | 10 | 70 | |
| 3 | Албан хаагч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, албан хаагчийн хууль ёсны эрх ашиг зөрчигдсөн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх чиглэлээр зохион байгуулсан ажил | 60 | 10 | 70 | |
| 4 | Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар хороодын үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, удирдамж чиглэлээр хангаж ажилласан байдал | 60 | 10 | 70 | |
| 5 | Авлигын эсрэг үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулсан ажил | 60 | 10 | 70 | |
| 6 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | 60 | 10 | 70 | |
| **Дундаж оноо:** | | | | 70 | |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино, дунд хугацааны болон цахим сургалтад хамрагдах | 100% | 15 | |
| 2 | Албан хэрэг хөтлөлтийн талаарх мэдлэгээ дээшлүүлэх | 100% | 15 | |
| | **Дундаж оноо:** | | 15 | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1 | Хандлага, ёс зүй | 6 | |
| 2 | Дүн шинжилгээ хийх | 5 | |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 5 | |
| 4 | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5 | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| | **Дундаж оноо:** | 6 | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1 | Хандлага, ёс зүй | 7,7 |
| 2 | Багаар ажиллах | 7,8 |
| 3 | Харилцаа | 7,8 |
| | **Дундаж оноо:** 7,8 | |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | 70 |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 15 |

| | | |
|---|---|---|
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Нэгжийн даргын үнэлгээ)* | 6 |
| 4 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Хамт олны үнэлгээ)* | 7,8 |
| 5 | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 98,8. |

***Үнэлгээ өгсөн:***

***Нэгжийн дарга:***
Захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч .................................(Б.Хосбаяр)

2024.12.19 (огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***
Гаалийн улсын байцаагч ................................ (Л.Оюунгэрэл)

2024.12.19 (огноо)

***Үнэлгээг хянасан :***

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***
Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ................................ (Г.Энхтайван)

12/20, 2024 (огноо)

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***
Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч ................................ (Ө.Тэгшээ)

2024.12.20 (огноо)

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч:***
Гаалийн ерөнхий газрын дарга ................................ (Р.Отгонжаргал)

2024.12.20 (огноо)